

## СОЛОНГОС УЛСЫН ИРГЭНИЙ МОНГОЛ УЛСЫН ИРГЭНШИЛТЭЙ НАСАНД ХҮРЭЭГҮЙ ХҮҮХЭД, ЭСВЭЛ БНСУ-ЫН ИРГЭНТЭЙ ГЭРЛЭЖ ДУНДААСАА ТӨРСӨН ХҮҮХЭД (F- 2- 2)

### ОЛГОХ ХҮРЭЭ:

**F-2-2: Солонгос улсын иргэний Монгол улсын иргэншилтэй насанд хүрээгүй хүүхэд, эсвэл БНСУ-ын иргэнтэй гэрлэж дундаасаа төрсөн хүүхэд**

Солонгос улсын иргэний Монгол улсын иргэншилтэй насанд хүрээгүй хүүхэд, эсвэл БНСУ-ын иргэнтэй гэрлэж дундаасаа төрсөн хүүхдийн ангиллын визээр Монгол Улсаас БНСУ-д зорчихыг хүсч буй иргэн Солонгосын Виз Мэдүүлгийн Төвөөр дамжуулан виз мэдүүлнэ. Та нэг удаагийн, нэг жил хүртлэх виз мэдүүлэх боломжтой. Виз шалгагдах явцад БНСУ-ын ЭСЯ-аас нэмэлт бичиг баримтыг шаардах боломжтой.

### БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Виз мэдүүлгийн маягт (Сүүлийн 6 сарын дотор авахуулсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг)
2. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь (Виз мэдүүлж буй өдрөөс хойш хамгийн багадаа 6 сарын хүчинтэй байх)
3. Цагдаагийн газрын тодорхойлолт (18–аас дээш, 60-аас доош насны анх удаа зорчиж буй иргэнд хамаарна)
4. Сүрьеэгийн шинжилгээний бичиг (БНСУ-ын ЭСЯ-аас заасан эмнэлэг)

### УРИГЧ ТАЛЫН БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Урилга (Хавсралт маягтын дагуу) Урилган дээр хувийн тамгаа дарж, Тамганы гэрчилгээний эх хувийг хавсаргах (Нотариатаар баталгаажуулах)
  2. Батлан даалтын бичиг (Хавсралт маягтын дагуу, Батлан даах хугацаа: БНСУ-ын хилээр нэвтэрсэн өдрөөс эхлээд 2 жил)
  3. Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох бичиг (Төрсний бүртгэлийн лавлагаа эсвэл ДНК шинжилгээний тодорхойлолт зэргээр төрсөн эцэг/эх хүү/охин эсэхийг баталгаажуулах албан ёсны бичиг баримт)
  4. Оршин суух хаягийг нотлох бичиг баримт
    - Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар, Түрээсийн гэрээ (Хамаарах тохиолдолд)
  5. Уригчийн санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
    - Орлого нотлох тодорхойлолт (Татварын Ерөнхий Газар), Ажлын газрын тодорхойлолт, Дансны хуулга зэрэг зээл төлбөр мэдээллийн лавлагаа (БНСУ-ын Банкны Холбооноос авах)
- ø Өөрийн болон хамт амьдарч буй шууд холбоо хамааралтай гэр бүлийн гишүүд болон эхнэр/нөхөр (Уригдагч)-ийн виз мэдүүлэх өдрийг хүртэлх сүүлийн 1 жилийн орлогын нийт хэмжээ нь өнгөрсөн онд БНСУ-ын Төв банкнаас зарласан нэг хүнд ногдох үндэсний нийт орлого (GNI)-ын хэмжээнээс дээш байх
- ø 2015 оны байдлаар нэг хүнд ногдох (GNI) нь 29,680,000 вон
- ø Хамт амьдарч буй гэр бүлийн гишүүдийн тоо 3 ба түүнээс доош байх тохиолдолд GNI-ийн 70%-аас дээш байх (20,776,000 вон)
6. Солонгос иргэн өөрийн Монгол улсын иргэншилтэй хүүхдээ урьж байгаа тохиолдолд асран хамгаалах эрх бүхий холбогдох нотлох бичиг баримтыг бүрдүүлэх ба байхгүй тохиолдолд тухайн насанд хүрээгүй хүүхэдтэй ижил иргэншилтэй асран хамгаалагч харгалзан дэмжигчийн зөвшөөрлийн бичгийг бүрдүүлж өгнө.

### ø Анхаарах зүйлс

**Асран хамгаалагч харгалзан дэмжигч байхгүй тохиолдолд, байхгүй нь үнэн гэдгийг нотлох албан ёсны бичиг баримт эсвэл нотариатаар баталгаажуулсан бичиг баримт**